

# **ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА**

# ЮАНИЙН БҮСЖИЛТИЙН ЛОГИК ШАЛТГААН, МОНГОЛ УЛСАД УРСАН ОРЖ БАЙГАА БАЙДАЛ<sup>1</sup>

М.Бүрэнжаргал<sup>2</sup>

## *1. Мөнгөний мөн чанараас юанийн хил дамнасан урсгалын логик шалтгааныг шинжлэх нь*

**М**өнгөний хөдөлгөөнт шинж чанар нь юанийн хил давсан урсгалыг нөхцөлдүүлж, түүхийн онцгой нөхцөлд юань хөрш оронд урсан оржээ. Хятад ба хөрш орны хоорондох эдийн засгийн харилцаан дахь юанийн хил дамнасан эргэлт нь Хятадын дотоод дахь эд баялагийн өсөлтөөс үүдэлтэй. Дэлхийн бараа таваарын худалдаа хийгээд соёлын солилцоогоор дамжин юань аажмаар дотоодын валют байхын зэрэгцээ гадаад валют болж хөгжсөн юм.

Юань хил дамнан эргэлдэж эхэлсэн тэр мөчөөс эхлээд түүний үндсэн чиг үүрэг хийгээд шинж чанарт гүн гүнзгий хувиралт гарч, зөвхөн энгийн үндэсний валют байснаа бүс нутгийн ба олон улсын чанартай валют болсон байна. Үндэсний валют тус орны хилийг давж бусад улс буюу бүс нутагт урсан орж эргэлдэх үед хүмүүс айлчлан зочлохдоо хамгийн гоё цэвэр хувцсаа өмсдөгийн адилаар тухайн валют нь билэг тэмдгийг илэрхийлсэн шинж чанарын хувьд улс орныхоо үзэл суртал, байр суурийг харуулж байдаг. Тухайлбал, юанийн хил давж эргэлдэж байгаа үзэгдэл нь Хятадын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлогын илрэл болохын

---

<sup>1</sup>Тус өгүүлэл нь Хятадын боловсролын яамны хүмүүнлэг ба нийгмийн шинжлэх ухааны төслийн бүтээл болно /该论文为中国教育部人文社科项目(11YJCGJW003)研究成果之一。

<sup>2</sup>М.Бүрэнжаргал: Бээжин дэх Төвийн санхүү эдийн засгийн их сургуулийн эдийн засгийн ухааны доктор/ 中央财经大学经济学博士后, ӨМИС-ын МСС-ын багш/内蒙古大学蒙古学学院教师.

зэрэгцээ бас бүс нутгийн эдийн засгийн хөгжилд Хятадын өвөрмөц байр суурийг харуулдаг. Гуч гаруй жилийн өөрчлөн байгуулалт, шинэчлэлт, урт хугацаанд эдийн засгийн өндөр өсөлтийг ханган, дунджаар 9 хувиар өссөнөөр, Хятадын эдийн засаг аж үйлдвэржилтийн болон мэдээллийн технологийн шинжлэх ухааны хөгжлийн асуудлыг цогцоор шийдэх хөгжлийн үе шатанд шилжсэн юм. Урт хугацааны эдийн засгийн өндөр өсөлтийг ханган, 1,3 тэрбум хүн амтай эдийн засгийн нэгэн том цогц болсны улмаас юань хөрш орны зах зээл рүү тэлэн гарахыг аяндаа үүсгэн бий болгожээ.

Юанийн хил давж эргэлдэж байгаагийн гол гурван хөдөлгөгч хүч нь дотоодын эдийн засгийн хөгжил, хөрш орны эдийн засгийн хөгжил ба олон улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг ахиулах үйл явц болно. Дотоодын эдийн засгийн хөдөлгөгч хүчинд Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлт, газар зүйн байршлын давуу тал, тогтвортой бөгөөд нээлттэй болж байгаа мөнгө санхүүгийн орчин багтана. Хөрш орны эдийн засгийн нөлөөлөх хүчинд нөөц баялагийн харилцан нөхөх чанар, хөрш орнуудын зах зээлийн нээлттэй байдал, мөнгө санхүүгийн системийн өөрчлөлт зэрэг багтана. Хятад ба хөрш орнуудын хоорондын хамтын ажиллагааны хөдөлгөгч хүчинд гол төлөв хилийн арилжааны хөгжил, хилийн аялал жуулчлалын хөгжил, шууд хөрөнгө оруулалт, хил дамнасан арилжаанд юаниар тооцоо хийж буй байдал зэрэг багтана.

## ***2. Хилийн худалдаа, арилжааны өртөг ба юанийн бүс нутаг дахь чадавхийн өсөлт***

Бодит байдлаас харахад, хилийн арилжаа бол юанийн бүсжилтийг түлхэн ахиулсан хамгийн гол эдийн засгийн хүчин зүйл болжээ. Юанийн бүсжилтийн одоогийн тархацаас үзэхэд юань нь голдуу Хятадын эх газартай хиллэж байгаа хөгжиж байгаа олон улс

орнуудын хилээр орж тухайн оронд эргэлдэж байна. Тэдгээр хөрш орнуудын хамтын ажиллагааны онцлог нь газарзүйн байршлын хувьд Хятадтай хиллэж, хүмүүнлэг ба газар зүйн талаар харилцан төсөөтэй, хөгжиж байгаа улс орнууд юм. ХХ зууны 80-аад оны сүүлчээс эхлээд Хятад болон хөрш орнуудын хилийн харилцаа маш түргэн хурдацтай хөгжиж ирсэн. Хятадын байршлын өвөрмөц давуу тал нь түүний гадаад эдийн засгаа хөгжүүлэхэд онцгой давуу нөхцлийг бүрдүүлж өгчээ. Нэн ялангуяа ХХ зууны 90-ээд оноос Зүүн, Зүүн Өмнөд, Зүүн Хойд Азийн хөрш орнуудтай хийх хилийн худалдаа эрчимтэй хөгжсөн. Энэ хугацаанд ихэнх хөрш орнуудын дотоодын эдийн засгийн бүтэц тэнцвэртэй бус, гадаад валютгийн эх үүсвэр ихээр дутагдалтай, мөнгөн гүйлгээний зах зээл тогтворгүй, дээр нь Азийн санхүүгийн хямралын сөрөг нөлөө зэргээс шалтгаалан хилийн арилжаанд хоёр улсын хооронд хэрэглэх валют мөнгөний өртгийг тогтвортой байлгах, мөн цаг хугацаа орон зайн өртгийг бууруулах үүднээс арилжааны тооцоог юаниар хийдэг байв. Зарим хөрш орны эдийн засгийн бүтэц нь зохисгүй байхаас шалтгаалж урт хугацааны турш дотоодын эдийн засаг нь хөгжиж чадахгүй байв. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар доошилсон нь тэдгээр улсын экспортын хэмжээг багасгаж, гадаад гуйвуулга ихээр дутагдан, мөнгөн гүйлгээний байгууллага гадаад гуйвуулга шаардагчдын хэрэгцээг хангаж дийлэхгүй болж, гадаад гуйвуулгын өртөг ихээр нэмэгджээ. Жижиг улс орнуудын эдийн засгийн орчин дахь хөрөнгө мөнгөний дутагдал тэдний дотоодын мөнгөн гүйлгээний зах зээл тогтвортой байхад сөргөөр нөлөөж, ард иргэд тухайн орны үндэсний валютын өртгийн тогтвортой байдалд итгэлгүй болоход нөлөөлжээ. Арилжааны өртгийг багасгахын тулд хүмүүс хил дамнасан аялал жуулчлал ба хөрөнгө оруулалтын ажиллагаандаа тогтмол юанийг хэрэглэх болсон юм. Үүний улмаас нэн их хэмжээний юань хил дамнан урсах болж түүнийг дагалдан юанийн бүс нутаг руу эргэлдэх хөгжлийн хандлага бий болжээ.

Азийн санхүүгийн хямрал нь Азийн зарим жижиг улс орнуудын үндэсний валютад ноцтой цохилт өгсөн бөгөөд юань нь тогтвортой бөгөөд ханш нь өссөөр байгаагийн улмаас дэлхий нийтийн хөрөнгө эзэмшигчид хүлээн зөвшөөрөх болжээ. Хятадын гадаад худалдааны тасралтгүй өргөжилт хөгжлийг дагалдан юанийн солилцоонд өөрийн өртөг нь буурч, юаниар солилцох арилжааны хүрээ хэмжээ ихсэх тусам үр ашиг өгөөж нь нэмэгдэж, юанийн бүс нутгийн чанартай валютын чадавхи байнга дээшилж ирэв. Хураангуйлбал, хилийн чанадад юань эргэлдэх болсон нь мөнгөний мөн чанар ба хилийн арилжааны хөгжилтэй холбоотой юм. Газар зүйн байршил, хилийн худалдаа хийгээд арилжааны өртгийн бууралт зэрэг хүчин зүйлс нь юанийн бүс нутгийн валютын чадавхийг дээшлүүлсэн үндсэн шалтгаан болсон гэж үзэж байна.

### ***3. Юанийн Монгол Улсад урсан орж байгаа гол замууд***

2009 оноос хойш Хятадын засгийн газраас хил дамнасан арилжаанд юаниар тооцоо хийх туршилтын зарчмуудыг хэрэглэх болсноор хил дамнасан юанийн үйлчилгээ шинэ үе шатанд орж таваарын арилжаанаас гадна гадаад шууд хөрөнгө оруулалтанд юанийг хэрэглэж эхэлсэн. Юанийн Монголд урсан орж байгаа гол замыг доорх хэдэн төрөлд ангилж болох юм. Үүнд:

#### ***1. Хоёр орны арилжааны банкууд тооцоогоо юаниар хийх зам:***

2002 оны 2 дугаар сард Хятадын Хөдөө аж ахуйн банкны Өвөр Монголын салбар банк болон Монголын Худалдаа Хөгжлийн банк гэрээ байгуулан юанийн дансыг нээсэн анхдагч болсон. 2011 онд ӨМӨЗО ба Монгол улсын хоорондох юанийн тооцоо 9,8 тэрбумд хүрчээ. Тэр дундаас таваарын арилжаанд юаниар тооцоо хийсэн хэмжээ 9,2 тэрбум байж ӨМӨЗО-оос Монгол улсад экспортлосон

нийт өртгийн 51 хувийг эзэлжээ<sup>3</sup>. Монгол улстай хил дамнасан юанийн тооцоо нилээд их байгаагийн шалтгаан нь **нэгд**, юаниар тооцоо хийх нь Хятад Монголын хилийн харилцаанд өргөнөөр хэрэглэгдэх болсон, **хоёрт**, юанийн өртөг нь тогтвортой бөгөөд монголын хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрөгдөж байгаа, **гуравт**, Монголд юаниар тооцоо хийх нь дөхөм хялбар болсон байгаа зэрэгтэй холбоотой. 2013 оны эхээр Өвөр Монголын нийт 7 Хятадын хөрөнгө оруулалттай банк болон Монголын бүх 14 арилжааны банк хоорондоо юанийн нийт 38 харилцах дансыг нээсэн байна.

**2. Хоёр орны арилжааны банкуудын хоорондох дансны мөнгөний харилцаа хийгээд банкны картын үйлчилгээний зам:**

2009 оны 9 дүгээр сард Хятадын Гадаад гуйвуулгын менежментийн яам Монгол улстай арилжааны банкны дансны мөнгийг тооцоолох болон худалдаалахыг зөвшөөрч нэг жилд 600 сая ам.долларын дотор гүйлгээ хийх болсноор Хятад, Монгол хоёр орны банкны хооронд юань чөлөөтэй эргэлдэхэд шинэ замыг тавин өгчээ.

2010 оны 1 дүгээр сард Хятадын банкуудын холбоо болон Монголын Голомт банк хамтран юанийн стандарт картыг үйлчилгээнд гаргажээ. Энэ бол Хятадын банкны холбооноос анх удаа Гонконг болон Макао-гоос өөр оронд гаргасан юанийн карт юм. 2012 онд Монголд нийт 46000 гаруй банкны холбооны стандарт картыг гаргасан бөгөөд түүний дүнд юаниар тооцоо хийх банкуудын холбооны карт 12822 байж бүх картын 27.71 хувийг

---

<sup>3</sup> Хятадын төв банкны Хөх хот дахь салбар/中国人民银行呼和浩特中心支行: “2011 оны ӨМӨЗО-ы хил дамнасан юанийн ажлын үзүүлэлт” /《2011 年内蒙古自治区跨境人民币业务工作报告》, 2012.

эзэлжээ. 2012 онд Монголын гаргасан банкуудын холбооны картаар дэлхийн хэмжээнд 160 сая юаний гүйлгээ хийгдсэн байна<sup>4</sup>.

### **3. Хятад Монголын хоорондох юанийн бэлэн мөнгөний хил дамнасан зөвөрлөлтийн зам:**

2002 онд Эрээн хот дахь Хятадын Хөдөө аж ахуйн банк ба Монголын Худалдаа Хөгжлийн банк хамтран их хэмжээний юанийн бэлэн мөнгийг ачин тээвэрлэж хилээр нэвтрүүлэх хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Энэ нь юанийг бэлнээр хил гарган тээж зөвөрлөх төрийн бодлогын үндсийг тавьж өгсөн юм. Дараа нь мөн хоёр орны хоорондох юанийн бэлэн мөнгийг хилээр оруулж гаргах холбогдох дүрэм зарчмуудыг тогтоосон нь хоёр орны хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлжээ.

Хоёр орны хооронд данс нээсэн арилжааны банкуудын юанийн бэлэн мөнгөний шаардлага ихэссэнээр бэлэн мөнгө тээвэрлэх тоо тасралтгүй нэмэгдэх болжээ. 2010 онд Монголын талын арилжааны банк ӨМӨЗО-ы арилжааны банкуудаас нийт 99 удаа юанийн бэлэн мөнгийг тээвэрлэж ойролцоогоор нийт 2,671 тэрбум юань хүрчээ<sup>5</sup>. 2012 оны эцэс болоход Монголын 11 арилжааны банк Өвөр Монгол дахь 5-н Хятадын хөрөнгө оруулалттай банкнаас нийт 726 удаа юанийн бэлэн мөнгийг тээвэрлэж нийт хэмжээ нь 16,887 тэрбум юаньд хүрчээ<sup>6</sup>.

---

<sup>4</sup> Үи Вэн Жэн/余文建: “Юанийн Монгол улсад эргэлдэж байгаа байдал” /“关于人民币在蒙古国循环使用情况的调查分析”, Өвөр Монголын мөнгөн гүйлгээ судлал сэтгүүл/《内蒙古金融研究》, 2013 (6).

<sup>5</sup> Хятадын төв банкны Хөх хот дахь салбар банкны судалгааны групп/中国人民银行呼和浩特中心支行课题组: “Хятад Монголын хоорондох юанийн бэлэн мөнгөний хил дамнан урсаж байгаа байдал” /“中蒙人民币现钞跨境流通规模现状及地位用途”, Өвөр Монголын мөнгөн гүйлгээ судлал сэтгүүл/《内蒙古金融研究》, 2012 (3).

<sup>6</sup> Үи Вэн Жэн/余文建: “Юанийн Монгол улсад эргэлдэж байгаа байдал” /“关于人民币在蒙古国循环使用情况的调查分析” Өвөр Монголын мөнгөн гүйлгээ судлал сэтгүүл/《内蒙古金融研究》, 2013 (6).

#### 4. Хувь хүн юанийн бэлэн мөнгийг биедээ авч гарах зам

1993 оноос эхлээд Хятадын Төв банкнаас хувь хүн биедээ 20000 юань авч хилээр гарахыг зөвшөөрсөн нь юанийн бэлэн мөнгийг хилээр дамнан авч гарах, орох хууль зүйн үндэс суурийг тавьж өгчээ. Нэг талаар бодит амьдрал дээр хүмүүсийн хилийн боомтоор нааш цааш зорчихыг дагалдан юань хил дамжин урсаж байна. Нөгөө талаар зарим худалдаачид хууль зөрчин юанийг биедээ авч гарч байна. Урт хугацааны турш хувь хүний биедээ авч гарч байгаа юанийн бэлэн мөнгөний хэмжээ нилээд их байж, бараг нийт хил давсан бэлэн мөнгөний хэмжээний 47 хувийг эзэлж байна<sup>7</sup>. Холбогдох эх сурвалж материалаас үзэхэд, хилийн гаднах зах зээл дэх юанийн эргэлт нь нийтдээ хууль журмын дагуу явахгүй байгаа учраас хил дамнасан далд эдийн засгийн ажиллагааны дагуу нилээд хэмжээний юань хилийн гадна гарч байна. Иймд хууль зүйн хүрээн дэх эдийн засгийн ажиллагааны дагуу юанийн хил дамнасан урсгалыг нэг алхмаар ахиулж хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн ажиллагааг нэн эрүүлээр хөгжүүлэх нь чухал юм.

#### АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Ма. Бүрэнжаргал/布仁吉日嘎拉：“Юанийн бүсжилтийн асуудлын судлал” /《人民币区域化问题研究》，Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл/内蒙古出版集团，2011 он.
2. Лю Юн Жи/刘永佶：“Хятадын эдийн засгийн зөрчлийн тухай онол” /《中国经济矛盾论—中国政治经济学大纲》，Хятадын эдийн засаг хэвлэлийн хороо /中国经济出版社，2004 он.
3. Ли Дүн Рүн/李东荣：“Юанийн хил дамнасан ханш илтгэмж тооцоо, асуудал болон арга зам” /《人民币跨境计价结算：问题与思路，Хятадын мөнгөн гүйлгээ хэвлэлийн хороо/中国金融出版社，2009 он.

---

<sup>7</sup> Сүлд/苏利德：“Монгол улсад юанийг хэрэглэж байгаа байдал” /“对人民币现金跨境在蒙古国流动情况的调查”，Шинжилгээ судалгаа сэтгүүл/《调查研究》，2014（1）.